



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/68

Арвайхээр сум


Аймгийн 2023 оны “Тэргүүний баг”,
“Тэргүүний байгууллага”, “Аварга ажилтан”-аар
шалгаруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6, аймгийн Засаг даргын 2009 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 175 дугаар захирамжаар батлагдсан “Багийн жилийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт-үнэлгээ хийх, аймгийн тэргүүний баг шалгаруулан шагнах журам”-ын 3.4, 5.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн захирамжаар батлагдсан “Аймгийн Засаг даргаас олгох шагналын журмыг шинэчлэн батлах тухай” А/788 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арван долоодугаар жарны “Хилэнт эх” хэмээх модон луу жилийн Билгийн тооллын хаврын тэргүүн сар “Цагаан сар”-ын баярыг тохиолдуулан 2023 онд идэвх санаачилга, хөдөлмөр бүтээлээрээ манлайлан ажиллаж, амжилт гаргасан “Аймгийн тэргүүний баг”, “Аймгийн тэргүүний байгууллага”, “Аймгийн аварга ажилтан”-ыг шалгаруулж, хавсралтаар баталсугай.

2. Шагналд дагалдах 4,200,000 (дөрвөн сая хоёр зуун мянга) төгрөг, үнэмлэх, тэмдэг, өргөмжлөлийн үнэ 682,700 (зургаан зуун наян хоёр мянга долоон зуу) төгрөг, нийт 4,882,700 (дөрвөн сая найман зуун наян хоёр мянга долоон зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын Нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0145

Аймгийн Засаг даргын 2024 оны 1-дүгээр сарын 29-ны өдрийн 108-дугаар захирамжийн хавсралт



НЭГ. АЙМГИЙН 2023 ОНЫ ТЭРГҮҮНИЙ БАГ

Д/д	Багийн нэр	Багийн Засаг дарга	Дагалдах мөнгөн шагнал (төгрөгөөр)
1.	Арвайхээр сумын Зүлэгтийн 12 дугаар баг	Б.Хэрлэн	800,000
2.	Богд сумын Хөөврийн 2 дугаар баг	Д.Чулуунбат	500,000

ХОЁР. АЙМГИЙН 2023 ОНЫ ТЭРГҮҮНИЙ БАЙГУУЛЛАГА

Д/д	Байгууллагын нэр	Байгууллагын регистрийн дугаар	Дагалдах мөнгөн шагнал (төгрөгөөр)
1.	Итгэлт хүнс баялаг ХХК	3569195	300,000

ГУРАВ. АЙМГИЙН 2023 ОНЫ АВАРГА АЖИЛТАН

Д/д	Овог нэр	Эрхэл буй ажил, албан тушаал	Регистрийн дугаар	Дагалдах мөнгөн шагнал (төгрөгөөр)
1.	Баясгалангийн Батням	Тарагт сумын Хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч	ЙП85050616	200,000
2.	Ганхуягын Доржханд	Бат-Өлзий сумын Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн мэргэжилтэн	ЙБ86082509	200,000
3.	Даваадоржийн Мөнхнасан	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн МХНТ-ийн Мэдээгүйжүүлэг, АНГИО графийн эмч	ЙН86012417	200,000
4.	Чимэддоржийн Сүхбаатар	Өвөрхангай аймгийн Хархорин сумын Нэгдсэн эмнэлгийн Дотрын их эмч	ХЛ67073133	200,000
5.	Мөнхтогтохийн Чимэдбавуу	Баруунбаян-Улаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн Бага ангийн багш	ЙА72072803	200,000
6.	Жавхлангийн Бат-Ирээдүй	Политехник коллежийн Мэдээллийн технологийн багш	ЙД90122533	200,000
7.	Бямбадоржийн Бат-Эрдэнэ	Аймгийн музейд Тайлбарлагч, эрдэм шинжилгээний ажилтан	ЙН80063018	200,000
8.	Даржаагийн Загдсүрэн	Баянгол сумын Нийгмийн даатгалын байцаагч	ЙВ78122201	200,000
9.	Аюурзаны Бат-Эрдэнэ	Өвөрхангай аймгийн Онги Ус Суваг ОНӨААТҮГ-ын Худгийн моторчин, Усан сангийн харуул, ЦБ-ын сааралжийн оператор	ЙК68110515	200,000
10.	Зулзагын Дэмбэрэл	Арвайхээр тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-т Зам талбайн үйлчлэгч	ЙЮ70071571	200,000
11.	Гойтийзийн Батцэцэг	Японы Хүүхэд ивээх сангийн Өвөрхангай аймаг дахь салбарын Зохицуулагч	ВЮ79032501	200,000

12.	Эрдэнэбатын Насанжаргал	Баруунбаян-Улаан сумын Алтан говийн ой ХХК-ийн Захирал, ойн менежер	В300220116	200,000
13.	Гүнгээбуугийн Лхамхүү	Нямгэрэлт ХХК-ийн Захирал	ЙН75082914	200,000

-оОо-